



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 11050

Номгон

Баянхонгор сумын авто замд хяналт шалгалт
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 /в/ дэх заалт, Авто замын тухай хуулийн 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын авто замд хяналт, шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Хишигбаатар – Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: С.Хүрэлхуяг - Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, аймгийн ерөнхий архитектор

А.Дорж – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Д.Магвансүрэн – Мэргэжлийн хяналтын газрын Автозам, тээврийн хяналтын улсын ахлах байцаагч

А.Батхуяг – аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, хошууч

Т.Отгонбаатар – “Хот тохижилт” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга

Ж.Мөнхсоёл – Баянхонгор хотын захирагч

П.Баатар – Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн


Нарийн бичгийн дарга Т.Норовринчин – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн

601210520

2.

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Хишигбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН